

**ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ
ЗАРИМ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж, Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж тус тус заасан.

Түүнчлэн, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.3 дахь заалтад иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байхаар, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1 дэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газар нь хүний эрх, эрх чөлөө, жендэрийн эрх тэгш байдлыг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авна.” гэж, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт Засгийн газар нь “Олон улсын гэрээгээр Монголын талын хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгаж, зохион байгуулах” чиг үүргийг хэрэгжүүлэхээр, Олон улсын гэрээний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт “Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх, хүний эрхийг хангах бодлого, хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт хүргэх, нийгмийн бүх харилцаанд хүний эрхийг бүрэн хангасан тогтолцоог төлөвшүүлэх ажлыг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1.14 дэх заалтад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх,

үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр заасан.

Мөн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2023 оны 114 дүгээр тогтоолын 2 дахь хэсгийн 3/ дэд заалтад олон улсын гэрээ, конвенцод дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон.

1.2.Практик шаардлага

Монгол Улс 1961 оноос Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн болсноос хойш Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагаас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 70 гаруй гэрээнд, үүнээс хүний эрхийн суурь 18 гэрээний 17-д нэгдэн ороод байна. Монгол Улсад шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хүн эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн бие даасан 590 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

2020 оноос хойших хугацаанд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хүний эрхийг хангах чиглэлээр эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, авлигатай тэмцэх цогц бодлого, шүүх эрх мэдлийн шинэтгэл, мэдээллийн ил тод байдлыг хангах, хүний хувийн мэдээллийг хамгаалах, төрийн үйл ажиллагааны шуурхай байдлыг хангахад чиглэсэн цахимын багц хуулиуд, боловсролын багц хуулиуд, нийгмийн даатгал, халамжийн багц хуулиуд, хөдөлмөрлөх эрх, хүүхдийн эрхийг хангах хамгаалах чиглэлээр холбогдох хуулиудын шинэчилсэн найруулгыг боловсруулж, Улсын Их Хурлаас баталж хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаанд тодорхой дэвшил гарган ажиллаж байна.

Монгол Улс 2023 онд Америкийн Нэгдсэн Улсын Freedom House олон улсын төрийн бус байгууллагын судалгаагаар улс төрийн эрх чөлөөний хувьд 40 оноо авахаас 36 оноо, иргэний эрх чөлөөний хувьд 60 оноо авахаас 48 оноо, нийт 100 оноо авахаас 84 оноо авснаар эрх чөлөөт улсын ангилалд багтаж байна. Хэдийгээр нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, эрх чөлөөг хангах хамгаалах, эрх зүйн таатай орчин бүрдүүлж, хүний эрхийг хангах, хамгаалах байгууллагуудыг байгуулж тодорхой үр дүн гарч байгаа ч хүний эрхийн зөрчил, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байсаар байна.

Монгол Улс амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, эрүүдэн шүүхээс ангид байх, шударга шүүхээр шүүлгэх, хохирлоо шударгаар барагдуулах, хувийн мэдээлэл халдашгүй байх, эвлэлдэн нэгдэх, жагсах, цуглах, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэлтэй байх зэрэг иргэний болон улс төрийн эрхийг бодитойгоор баталгаатай эдлүүлэх шаардлагатай байгааг хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцооноос зөвлөсөөр байна.

Монгол Улс хүний эрхийн олон улсын гэрээнд нэгдэн орохын зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн болон гэрээний механизмуудыг идэвхтэй ашиглаж хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй анхаарч ажиллаж байна.

Хүний эрхийн олон улсын гэрээнд нэгдэн орсноор тухайн гэрээ, конвенцуудыг бодитойгоор хэрэгжүүлэх, түүний биелэлтийг тодорхой хугацаанд тайлагнах үүргийг хүлээдэг. Монгол Улсын Засгийн газар хүний эрхийн нэгдэн орж соёрхон баталсан үндсэн гэрээ, конвенцын хүрээнд 1971-2023 онд нийт 57 илтгэл, Хүний эрхийн зөвлөлд Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг /UPR/-т 3 илтгэлийг тус тус хүргүүлсэн байдаг.

Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлсний мөрөөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс нийт 170 зөвлөмжийг өгснийг бид үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Түүнчлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь 2001-2024 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлын талаарх нийт 23 удаагийн илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн хүний эрхийг хангах хууль эрх зүйн орчныг сайжруулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг арилгах, хүний эрхийг хамгаалахтай холбоотой саналыг танилцуулж, илтгэлийн мөрөөр авах арга хэмжээний талаар Улсын Их Хурлаас холбогдох шийдвэрүүд баталж ирсэн байдаг. Дээрх илтгэлүүдэд иргэний болон улс төрийн эрхүүд, тухайлбал, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, тайван жагсаал, цуглаан хийх, амьд явах эрх, сонгох, сонгогдох эрх, халдашгүй чөлөөтэй байх эрх, өргөдөл гомдлоо шийдвэрлүүлэх эрх, эрүү шүүлт ба хүний эрх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх, түүнчлэн эдийн засаг, нийгэм соёлын эрхүүд, тухайлбал, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрх, сурч боловсрох эрх, хөдөлмөрлөх эрх, хүний эрхийн боловсрол, аж ахуй эрхлэх, зохистой хоол хүнсээр хангагдах эрх, зорилтот бүлгийн эрхүүд, тухайлбал, хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, үндэсний цөөнхийн эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүн худалдаалах гэмт хэрэг ба хүний эрх, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийн талаар тусгасаар ирсэн байна.

Түүнчлэн, Хүний эрхийн Үндэсний Комисст ирүүлсэн нийт гомдол мэдээллийн дийлэнх нь ажлын байрны дарамт, хууль бусаар цагдан хорих, төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрх, хүүхдийн эрх, хилс хэрэгт холбогдсон гэх асуудал, эд мөнгөний тусламж авах, нэр төрийн халдашгүй байдал зөрчигдсөн тухай, хууль зүйн туслалцаа авах эрх зэрэг байгааг мөн анхаарч үзэх шаардлагатай байна.

Мөн “Хүний эрх-Дэвшилтэт бодлогын хүрээлэн” төрийн бус байгууллагаас Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл сэдэвт тойм судалгааг хийж, хүний үндсэн эрхүүдээс нэн тэргүүнд анхаарах шаардлагатайг сонгон эрх тус бүрийн гол агуулга, ахиц дэвшил, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замд анализ хийж, тодорхой зөвлөмжүүдийг боловсруулсан байдаг. Тус дүгнэлт, зөвлөмжүүдийн үндэслэн иргэний болон улс төрийн эрхийг хангах чиглэлээрх зарим арга хэмжээг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хүний эрхэд тавьж буй хориглолт, хязгаарлалтыг хуульд тодорхой заах, хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байх, хязгаарлалт нь эдгээр зорилгын нэгэнд хүрэхэд зайлшгүй, тохирсон байх, үндсэн эрхийг аль болох эдлүүлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, туйлын эрх зөрчөөгүй байх, хараат бус шүүхээр хянагддаг байх

гэсэн тулгуур зарчмыг баримтлахыг шаарддаг. Иймээс хүний эрх, эрх чөлөөг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа байдлыг ч мөн өөрчилж, тухайн зохицуулалтыг дээрх тулгуур зарчмуудыг баримтлан хуульд тусгах замаар шийдвэрлэх шаардлагатай асуудлууд ч мөн байсаар байна.

Үүнтэй холбогдуулан, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй нийт актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд тус хуралдаанаас Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хуулиар тусгайлан эрх олгосон заалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг даалгасны дагуу төрийн захиргааны төв байгууллагууд өөрсдийн эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомжийн төслийг тус тус боловсруулж байна.

Хууль зүй, дотоод хэргийн салбарт хамаарах Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 35 хуулиар 160 гаруй дүрэм, журам батлах эрхийг Засгийн газар, Засгийн газрын гишүүн болон агентлаг, байгууллагын даргад олгосон байгаагаас 50 орчим хувь нь хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай буюу хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, тухайн харилцаанд оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжтэй зохицуулалт гэж үзэн нийт 29 хуулийн төслийг боловсруулаад байна. Эдгээр нь хүний эрхийг хангах хүрээнд боловсруулах хуулийн төслүүдтэй агуулгын хувьд давхцахгүй, бие даасан үзэл баримтлалтай багц хуулийн төсөл болно.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасны дагуу Засгийн газар Комиссын илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийн биелэлтийг хариуцаж Улсын Их Хуралд илтгэх үүрэгтэй.

Ийнхүү “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын “2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хүний эрхийг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх зорилготой. Тус зорилгын хүрээнд дараах хуулийн төслийг боловсруулна:

1.Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцааны төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг энэ чиглэлд уялдуулан зохицуулах замаар Монгол Улсын иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах зохицуулалт бүхий Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

үүнтэй холбогдуулан Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

2.Эрүү шүүлт тулгах, хүчээр алга болгох гэмт хэргийн шинжийг олон улсын хүний эрхийн байгууллагын зөвлөмжид нийцүүлэн тодорхой болгох зорилгоор боловсруулах Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

3.Баривчлах шийтгэлийг оногдуулахгүй байх этгээдийн хүрээ хязгаарыг иргэдийн зүй ёсны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх, хуулийн тусгай ангид заасан зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах баривчлах шийтгэлийг цөөрүүлэх, Улсын Их Хурлаас баталсан зарим хуультай холбогдуулан зөрчилд тооцох үйлдлүүдийг шинээр тусгах зэрэг зохицуулалт бүхий Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

4.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтнуудад бий болдог хүндрэл, чирэгдлийг багасгах, цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх, зарим төрлийн хэргийн харьяаллын алдааг засах зохицуулалт бүхий Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үүнтэй холбогдуулан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;

5.Монгол Улсын иргэнийг Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх журмыг боловсронгуй болгох, хилийн хориг тавих эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоог хангах, сайдын шийдвэрээр зохицуулж байсан хүүхдийг хилээр нэвтрүүлэх журмыг хуулиар зохицуулах зорилготой Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

6.Албаны нууцын тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох, албаны нууцын хүрээ хязгаарыг багасгах, байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад хамааруулж байгаа зохицуулалтыг эргэн харах, иргэдийн мэдээлэл авах эрхийг хязгаарлаж байгааг арилгах зорилгоор боловсруулах Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

7.Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хараат бус байдлыг хангах, иргэний нийгмийн болон мэргэжлийн байгууллагын бодит оролцоог хангах, тэдгээрийг нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох зохицуулалтыг бий болгох зорилгоор боловсруулах Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

8.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх бүхий хуульчдад олон улсын гэрээ конвенцын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, уг асуудлыг хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт тусгах хөшүүрэг бий болгох зохицуулалт бүхий Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

9.Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулах шаардлагад хүний эрхийг хангах шалгуур бий болгох зохицуулалт бүхий Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгасан хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн зорилт, арга хэмжээг бодитойгоор хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Түүнчлэн, олон улсын гэрээ, конвенцуудад Монгол Улсын хууль тогтоомжийг нийцүүлэх үйл ажиллагаанд ахиц дэвшил гарч, хүний эрхийн олон улсын механизмуудаас зөвлөсөн зөвлөмжүүд, мөн Монгол Улсын хүний эрхийн үндэсний байгууллага болох Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний эрх, эрх чөлөөний байдлын жил бүрийн илтгэлүүдээр өгсөн зөвлөмжийг Засгийн газраас хэрэгжүүлж холбогдох арга хэмжээг авдаг байдал хэвшиж тогтоход чухал ач холбогдолтой.

Мөн хүний эрхийг хангах, хамгаалахад иргэний нийгмийн байгууллагуудын дуу хоолой, санал, дүгнэлтийг хүлээн авч, тэдгээрийн оролцоог хангах, иргэний эрхийг ялангуяа тусгай бүрэн эрхийг хэрэгжүүлдэг төр, түүнийг төлөөлсөн этгээдийн зүгээс иргэдийг эрхийг хангах, хамгаалах, үндсэн эрхийг бодитойгоор, бүрэн эдлүүлдэг байх эрх зүйн орчин сайжирна.

Хэдийгээр олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүрэг, тэдгээрийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, хүний эрхийн үндэсний байгууллага, төрийн бус байгууллагуудын санал, эрх бүхий байгууллагаас Засгийн газарт даалгасан арга хэмжээ, хүний эрхтэй холбоотой бүх зөрчил, дутагдлыг хуулиар нэг дор арилгаж, засах боломжгүй боловч энэхүү хуулийн төсөл батлагдсанаар хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад томоохон дэвшил авчрах боломжтой болж цаашид хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн бусад хууль тогтоомжийн төслийг тодорхой төлөвлөлт, үе шаттайгаар боловсруулах болно.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулах хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

---oOo---